

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чимэдийн Дамиран	Дугаар	L246
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Мандал-Овоо сум
Төрсөн газар	Мандал-Овоо сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шар хулсны хийд	Сүм хийдийн дугаар	ӨГМО 004
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Шар хулсны хийд

Гантулга: За та энэ сүм хийдийн тухай товч мэдээлэл өгнө үү?

Дамиран: За тэгэхээр энэ мэдэх юм ч их бага даа. За Батхүү бас дуулсан юмаа ярина биз. Надад дуулсан юм л байна уу гэхээс нүдээр үзээд хараад байж байсан юм бол багахан. За энэ миний дуулснаар бол хэддүгээр зуунд ч байдаг юм, дөрвөн газраас дөрвөн шинжээч ирж одоо Хятад, Төвд, Энэтхэг за Монголоос нэг хүн орж байсан юм гэдэг байх. Хичнээн хүн орж байсан хэн мэдэхэв, хичнээн ч улсууд явж байсан юм. За ямар ч байсан дөрвөн газрын их шинжээч нар иржэнэ хийдийг байгуулж байсан юм гэнэ лээ, энэ Шар хулсны хийдийг. Тийм түүх намтартай юм байна лээ. Дөрвөн газрын их том шинжээч нар ирж байгуулсан гэж байгаа ш дээ. Тэр энэ бол нэлээн, тэр үедээ нэлээн одоо ч гэсэн их дуулиантай юм байхаар байгаа. Олон газрын их том шинжээч нар ирж энийг байгуулна гэдэг бол бас том оо намтартай юм шиг байгаа юм.

Гантулга: Энэ газрынх нь шинжэийг одоо эргэн тойронд нь энд нь ийм уул байна гээд ингээд газрынх нь шинжийг харвал?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамиран: За тэрийг бол ерөөсөө мэдэх юм байхгүй.

Гантулга: Үгүй яахав, одоо нутгийнхаа уул усных нь нэрээр одоо зүүн талд нь тийм юм байна гээд?

Дамиран: Энэ бол одоо тийшээ жаахан хонхордуу газар, тэгээд л одоо Халтарты Халтар хошуу, тэгээд энэ Бүдүүн Хүрэн ч гэж байх, шиг, тахилгат овоо ч гэж байх шиг, баруун тийшээ нь явсан юм. За хойно нь Сухайн хулж ч гэж байх шиг. Ийм газруудын дунд л одоо бий болсон ийм хийд юм л даа. За тэгэхээр би болвол одоо тав, зургаан настай бас гайгүй мэдээ орчихсон байсан үе. Намайг энд ирж ээж минь одоо дуганд мөргүүлж байлаа. За нэг л их том сайхан дуган. Ер нь л их сонин сайхан газар байсан. Үүдэндээ нэг тийм том, одоо сайн санахгүй байна. Тийм арц уугуулдаг ...

Гантулга: Бойпор?

Дамиран: Тийм цогтой бойпортой л байсан юм. Бас нэг тийм тулгагь тогоо байсныг би мэддэг юм. Тэр нь одоо чухам ямар учиртай байсныг мэдэхгүй юм. Тэр нь яадаг юм байсан юм.

Гантулга: Тэр нь хаана нь байсан юм бэ?

Дамиран: Тэр бойпорынхоо зүүхэн талд байдаг байсан юм. Тийм том тулгатай, тэгэд дээр нь нэ бүрийн бичиг сажигтай, бодвол тэр ном л биз. Нэг тийм хүрэл тогоо. Үгүй тийм юм байдаг байсан байгаа юм, тэр нь одоо ямар учиртай байсныг би мэдэхгүй юм. Тэгээд одоо нэг үзсэн юм гэвэл тэр л байгаа юм.

Гантулга: Ер нь ингээд харахад том жижгээрээ том цогчин дуган байсан уу?

Дамиран: Том дуган, ер нь бол бүр том дуган даа, том дуган байсан юм. Чухам одоо энэ хот газрын хүрээний хажууд чиг л том л дуган байсан даа. Нэг зуугаад ламтай байсан гэдэг билүү, Батхүү? Нэг зуугаад ламтай байсан гэдэг байх. За тэгээд одоо гадаадын том том эрдэмтэй лам нар байсан гэдэг юм.

Гантулга: Энэ Ойролцоо байсан сүм, хийд хурлуудыг нэрлэвэл? Энэ ойролцоо нутгийн энэ Хулсан хурлын ойролцоо эргэн тойрон байгаа хошуу хурал номыг нэрлэвэл одоо харилцаа холбоотой ч гэдэг юм уу?

Дамиран: Үгүй одоо харилцаа холбоо байсан л байлгүй дээ. Одоо энэ цамтай газар чинь тэр Хошуу хийдийн хурал л байж. Энэ дээр одо тийм цам мам ямар юм байсан юм уу, үгүй юм уу. За ямар ч байсан эргэл мөргөл хийдэг, ном уншдаг, за ганжуур эргэнэ ч билүү ямар юм билээ. Тэгээд энэ нэг гороо гэж нэг яригдаад байдаг юм.

Гантулга: Гороо эргэдэг?

Дамиран: Тийм. Ном үзсэн, хүүхдээ арганд хийгээд үүрчихсэн улсууд ингээд л эргээд л тойроод л явж байдаг билээ. Тэрнийг бол би бас тэр үед нь үзэж л байсан. Би ч гэсэн бас арганд хийгээд намайг эргүүлээд байхад нь явж байсан юм гэнэ лээ. Тэгээд одоо энэ энүүхэн хавьд шиг л санагдаад байгаа юм, нэг том суварга байсан даа. Яг л энэ оройд байсан байгаа байлгүй. Тийм, нэг том суварга байсан, тэгээд басжижгэн суварганууд байсан санагдах юм.

Гантулга: Цогчин дуганаараа баримжаалж яривал яг хаахна хаахна байсан байх вэ?

Дамиран: Зүүн хойноо басан болов уу гэж санаад байдаг юм аа. Одоо яг ард нь байгаагүй шиг санаад байгаа юм даа. Тэр ч одоо тэгээд л сайн мээдхгүй л байна. Гол мэддэг улсууд нь энүүгээр одоо барагдчихсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ одоо түрүүн Азар лам мам гээд олон газрын юу яаж байсан гээд ярьж байна.Төвдийн ийм сүмээс ийм лам байсан, одоо ингэж ирж очиж байсан гэдэг ч юм уу?

Дамиран: Тэр Азар лам гэдэг чинь тэр Төвд л хүн байсан юм шиг байгаа юм. За тэгээд тэр Ямпил Төвд гэдэг чинь бас мундаг л хүн байсан гэж байгаа юм.

Гантулга: Ямдил Төвд ээ?

Дамиран: Ямпил Төвд.Батхүү мэднэ дээ, Тэр одоо бас мундаг л хүн байсан юм гэнэ лээ.Тэр ловон багш гэж нэг хүн байжээ.Тэр одоо Монгол хүн байсан юм уу, үгүй юм уу тэрнийг одоо мэдэхгүй юм.

Гантулга: Төвд хүн байсан юм уу?

Дамиран: Хэн мэдэхэв, Төвд хүн байсан юм уу үгүй юм уу.Тэр одоо бас мундаг л хүн байсан гэж байгаа юм.

Гантулга: Энэ хийд дээр сууж байсан?

Дамиран: Тийм.Нэлээн л том ламын нэг. За тэр оточ, маарамба гэж байсан л байна. Тэр нь ямар ч улс байсан юм.Ер нь энэ шашны төрлийн тэгээд л бүх л юм энд байсан байгаа юм л даа.Тэр л зурхайч, мурхайч юу байдаг юм.Бүх л юм байсан байгаа юм.

Гантулга: Энэ одоо урсгал, чиглэлээр нь яривал, шарын шашны хийд байсан гэдэг юм уу, тэр талаар дуулсан юм байна уу?

Дамиран: Тэрнийг бол би мэдэхгүй. Энэ Батхүү мэдэж байдаг юм уу , чухам.Одоо шарын шашин байсан юм уу, Буддагийн шашин байсан юм уу тэрийг бол би мэдэхгүй.

Гантулга: Тойроод бол суварга байсан гэж байна ш дээ?

Дамиран: Хэдэн суварга байсан, ямар ямар суварга байсан? Өндөр нам ч гэдэг юм уу, суварга чинь бас дотроо бодь суварга энэ тэр гээд байдаг.Тийм нэр үс байсан болов уу?

Дамиран: За ерөөсөө мэдэхгүй юм даа.Ямар ч байсан тэр үед байж байсан.Тэр байх ч ёстой юм байх.Энийг бол тийм нэлээн хөөрхөн хийж байсан юм даа, тийм.

Гантулга: Энэ хийдээ бол одоо цогчин дуганаа барьсан материал энэ тэр гэвэл, нутгийн өмнө талаар тэр Шороон булгийн ард байсан гээд та түрүү бас дурсаж байсан?

Дамиран: Тийм.

Гантулга: Тэр талаар бас жаахан дэлгэрэнгүй яривал, одоо барилгын материал бол нэлэн олдоц сайтай байсан юм байна ш дээ?

Дамиран: Сайтай, сайтай.

Гантулга: Ямар ямрыг нь эндээсээ авч байсан юм, ер нь юугаар барьж байсан юм, тэр талаар санаж байгаа юм бол?

Дамиран: Энэ Тахь гэж нэг газар бий. Тахь Мөнгөн согоот гэж.

Гантулга: Урагшаагаа юу?

Дамиран: Тийм. Тэрний зүүн талд энэ зөн гэдэг юмыг шатааж байсан гэж байгаа юм. Тийм.

Гантулга: Хятадууд шатааж байх уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамиран: Одоо бодвол тийм л байсан байх даа. Энэ зөн гэдэг юмыг л тэнд шатааж байсан гэж байгаа. Хуучуул тэгж ярьдаг байсан. Тэнд зөнгий нь шатаадаг тийм бааюу байсан гэж. За бодвол тэрүүгээр л хийдэг байсан байх даа.

Гантулга: Зөнгийн нь тэрүүгээр?

Дамиран: Тийм. За тэр үед энэ ойгын энэ үнэт шавруудыг чинь ашиглаж байсан юм уу, үгүй юм уу мэдэхгүй юм. За сүүлийн үед тавин хэдэн оны үед энэ артел гэдэг юм байгуулагдаад тэрнийг ашиглаж байсан тэр улбааг үндэслэж байсан болов уу гэж би боддог юм. Төрөл бүрийн шороо бий. Одоо байж л байгаа.

Гантулга: Аан шороон будаг?

Дамиран: Тийм, нэг гурил шиг юм. Тэрийг чинь шүүгээд л, өнгө өнгөөр нь саванд шүүгээд л, тэгээд л хутгаад л өнөөхийг чин. Зүгээр нэг тунарсан ус болчихно ш дээ. Тэр усыг нь дор нь хийж авчихаад, өшөө саванд. Хүрэн бол хүрэн, цагаан бол цагаан, ногоон бол ногоон. Төрөл бүр байгаа юм чинь. Усыг нь шүүж аваад л, тэгээд л үлдсэн савандаа бас нэг ус хийж авчихаад л тэрнийг чинь л тэгээд хутгаад л... Цохиж нүддэг байсан юм уу үгүй юм уу, ямар ч байсан сайн л хутгадаг байсан юм. Тэгээд л хийгээд байна. Тэгээд орчихно, саванд хийгээд. Тэгээд маргааш өглөө нь босоход өнөөх чинь ёроолдоо лаг болчихсон. Тэрнийг бол би нүдэр үзэж байсан юм чинь, тийм лаг болчихсон байна. Тэгээд нөгөө ус чинь сайхан туначихса юм чинь, тэрийг нь асгаад. Асгадаг ч байсан юм уу, саванд хийдэг ч байсан юм уу. Тэгээд өнөө лаг шавар дээр нь дахиад ус хийгээд, өнөөхийг чинь зайлаад. Тэгээд шингэнийг нь өшөө сав руу хийчихнэ. Тэгээд ёроолдоо нэг их шаар үлдээд байхаа байх дээр нь зэрэг л болсон гэж үздэг юм шиг байгаа юм. Тэгээд энийгээ тавьчихна. Тэгээд тэр чинь мөн шавар нэмдэг учраас, усныхаа ёроолд тунад ингээд нэг лаг хавтгай юм үлддэг байсан байгаа юм. Тэгээд л өнөө лаган дээр чинь одоо тэрнийг чинь аваад л саван дотор хийгээд л тэр чигт нь хийдэг байсан болов уу гэж санаад байгаа юм. Өнөө хоньны бууцыг чирээд овоолчихсон байдаг ш дээ. Тэрнийг чинь нөгөө ногоонд чинь ногоон, хард чинь хар хүрэнд чинь хүрэн...

Гантулга: Будаг, өнгө оруулах...?

Дамиран: Тийм. Тэгээд л будаг хийнэ. Нэг их олон сайхан өнгийн ус гараад ирнэ. За тэрнийг чинь тэр бодвол байван гэж будаг тогтоодог юм байж. Манай муу эгч энэ чагнаа гэдэг хүнтэй ханилсан юм байж, тэгээд л өнөөхийг чинь хүрч ирээд л хараад л, байхгүй. Тэгээд л байвантай усанд л өнөөхийг чинь хийчихнэ дээ. Том том саванд, тэгээд л өнөө байван хийгээд л дэвтээгээд л орчихно, өнөөхийг чинь. Тэгчихээд л аль хэр үддэг байсан юм одоо, будаг нь болж гүйцтэл л.. Тэгээд л өнөөхийг чинь гаргаж ирээд малтаад базааад авчихна. Тэгээд дахиад нэг цэвэр усанд угаана. Ёстой тэр будаг гарна аа гэж гонж. Одоо нэг сайн будагтай даавуу, ямарч усанд угаагаад өнгө нь хэвээрээ байдаг. Яг тэрэн шиг.

Гантулга: Ерөөсөө будаг гарахгүй л байх нь ээ?

Дамиран: Тэгээд л тогтчихно. Тэгээд л тэрүүгээр чинь хивс л нэхнэ дээ.

Гантулга: Тэгвэл одоо тэр будгийг ашиглаж бол тухайн үед барилгын юманд бол хэрэглэж байсан байх гээд байна, тийм ээ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамиран: Тийм.

Гантулга: Тэр олон жил л ...?

Дамиран: Тэр олон жил л үндэс нь байсан байх гэж би бодож байна.

Гантулга: Энэ гол цогчин дуган гээд л ганц том дуган байсан гэж байна ш дээ. Энэ одоо бас хааш хаашаагаа алхмаар ч гэдэг юм уу, нүдний хэмжээгээр яривал, метрээр ч гэдэг юм уу багцаагаар хэдий хэмжээний байсан бол, Та санаж байвал?

Дамиран: Үгүй одоо юу гшэж ярьдаг байв даа. Өнөө Гончиграш гэж өвгөн байв даа. Үгүй тэр чинь хааш хаашаагаа хорин таван метр гэдэг байлуу. Хай даа тэр мэдэхгүй юм. Зүгээр энэ дугануудын хэлбэр галбирыг ажаад байхад одоо Эрдэнэдалай сумын тэр Сангийн далай хийд гэж. Тэр хийдийн цогчин дуган, энэ хийдийн цогчин дуган хоёр бол ерөөсөө нэг л хэвийн байсан гэж ярьдаг юм. Ерөөсөө хэмжээний хувьд бол. Ерөөсөө нэгийг нь л үзвэл тэр одоо хэдий хэмжээтэй барьдаг байж гэдгийг одоо Эрдэнэдалайгаас л бол тэр сангийн далай хийдээс л бол...

Гантулга: Одоо тэр дуган нь байгаа юу?

Дамиран: Одоо байгаа. Тэр улаан дарцаг гэнэ үү авсан тэр дуган бол харин ч нэлээн аятайхан байгаа байх гэж санаж байна. Энэ хэлбэрийн хувьд бол би эрт үед бүрэн бүтэн байхад нь харж байсан юм. Тэгэхдээ бол агуулах болгочихсон. Ер нь дугануудыг агуулах л болгож. Зарим дуган бол, тэр Ханын цагаан суварганы дуган бол сургуулийн тэнхим гэж, сургуулийн байр болгож, хэдэн анги тасалгаа хийж. Тэнд би дөчин зургаан онд эхэлж сургуульд ороход тэр дуганд хичээллэж байсан юм. Тэгээд дөчин найман онд энэ дээр нүүж ирэхэд энэ дуган бол мөн хэвийн дуган байсан. Яг адилхан. Тэгэхээр дуганых нь хэмжээ бол энэнийх нь том, тэрнийх нь жижиг гэсэн юм бол байхгүй. Ер нь л ижил. Тэгэхээр дуган гэдэг энэ дугануудын хийдийг нь би тэгж сонссон юм байгаа юм. Хийдийн лам нар ямар ч байсан урд талаасаа хойд тал нь ахлаад байдаг учиртай байсан юм гэж. Ухаан нь энэ Ханын цагаан суварганы лам нар одоо хурал цуглаан болоход энэ Шар хулсан дэр ирдэг. Энэ өшөө томхон олон ламтай хурал цуглаан болоход Хошуу хийд дээр очдог байсан. Тэгэхээр энэ чинь хошуу нутгаа дамжсан, бас гадны хошуу руу явдаггүй байж шүү дээ, энэ чинь.

Гантулга: Тийм байна, тэр дотроо?

Дамиран: Тийм. Энэ Онгийн хийдүүд бол дээд тал нь ахлаад, хойд талын лам нар нь ахлаад энэ Онгийн хийд чинь тийм учиртай юм байж уу гэж би боддог юм. Энүүнд тэгээд агуулах хийж байгаад сүүлийн үед тэгээд нурчихсан. Энэнийг би бол дөчин найман олон анх нүдээр харсан. Тэгэхдээ тэр лам, дотор хийд эд нар өрчлөгдсөн юм байлгүй дээ, хэлмэгдсэн юм. Багачуулын нүдээр тэрийг сонирхсон юм. Тэгэхээр энэ хийдийг байгуулдаг гол аргачлал, энэ дэр бүүчихая гээд нгэг хүн цохлоод бүүчихдаггүй. Тэр мэргэд, зурхайч нар хамтарч шинжиж бүүсан нь тодорхой байдаг болов уу гэж санадаг юм. Эргэн тойрон энэ одоо бид нарын нүдээр ч харсан хүрээ хэрэм хэлбэрийн газар байгаа юм. Урд тал нь задгай, хойд талын энэ хойд ирмэгүүдийн хар, хоёр тал нь босоо ийм дугуй. Энэ хүрээн байгуулдаг бас нэлээн ирээдүйтэй, боломжтой ч гэдэг юм уу, хамгаалттай ч гэдэг юм уу.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Байгаль экологийн?

Дамиран: Байгаль экологийн их нарийн талтай байсан болов уу гэж санадаг юм.Өмнөө уух устай, харах хараатай. Энэ Гурван Сайхан, энэ хаанаас нь с харсан Гурван Сайханы орой ил л байж байгаа юм.Одоо бид ингээд л харж байгаа юм. Тэгээд л энэ чинь жаахан ийшихнээ явахлээр тэр чинь далдарна, ойрхноос хүрээлэгдэнэ. Хойд талаасаа далдтай, урд талаасаа ийм ханын хяруултай, ханын хяруултай ийм байдлаар энэ байгуулсан юм гэж санадаг юм.

Гантулга: Хэрэм хүрээнийх нь хэмжээг багцаагаар бодоход хааш хаашаага хэд байсан юм бол, ер нь нийт хүрээний хэмжээ, гадуур хүрээ, хэрэм? Энэ цогчин дуганых нь нийт хэмжээ гэдэг ч юм уу?

Дамиран: Аа энэ хэрэм байгаагүй байх. Үгүй ээ байсан ч юмуу хэн мэдэхэв. Намайг тэр дөчин найман онд ирэхэд л тийм хэрэм байгаагүй юм.Зүгээр жаал жуулхан нэг шавар хэрэм байсан байх.Тэгээд тэр гороо эргэнэ гэж байдаг шүү дээ. Тэрний чинь хэмжээ дандаа суварга байсан юм.Ингээд тойроод суварганууд.Тэр суварганы гадуур ингэж эргэдэг.

Гантулга: Аа мөн мөн. Энэ дээр ч хэдэн суварга байсныг мэдэхгүй юм. За ямар ч байсан нэг арваад суварга байдаг байсан байх .Тийм, тэрний гадуур чинь эргэнэ шүү дээ.Тэгээд нар зөв эргэнэ, хичнээн ч эргэдэг юм.Тэгээд зарим нь ном үүрчихсэн ч байна, намайг хүртэл ээж минь аргал хийгээд үүрээд явж байсан гэж байгаа юм. Тэрнийг бол би мэдэх юм биш, жоохон хүүхэд байхад. Тэгээд л хүүгээ тэгж гороо эргэж, буян үйлдэж, лам нараас хишиг гуйж ингэж явсан юм даа, миний муу хүүгээ гэж миний муу ээж чинь ярьдаг байлаа ш дээ.

Гантулга: Энэ одоо дуганы нөгөө зөнгийн байшин сүүлд нь хүн барьчихсан байхад, тэгээд зөнгийн нь харж байхад гадуураа очир мочирын хэлбэртэй ч гэдэг юм уу, чимэглэлийн талаар яривал? Энэ дуганыг барьсан барилгын материал дээр тавьсан чимэглэл гоёл, юунууд тэнд үлдсэн юм?

Дамиран: Аа тэр дээд талаар нь тиэр ганжир л юм даа, одоо.Том том зүүн дуур аваачаад очир, дандаа очир. Том том товойсон очир.Тэгээд дандаа хаашаа юм бэ дэ, тийм цэцгэрхүү ч байсан юм уу хаашаа юм.Тийм л хүрээтэй байдаг байсан. Гоё доо гоё тэр чинь тэгээд. Тэр чинь бас тэгээд тэр будаг шидваар ялгах юм байсан юм уу үгүй юм уу. Том дөрвөлжин тэр зөнгийн дээр байгаа хэлбэр бол ухаандаа одоо ийм гинж зуусан бад гэж хөөдөг.Бадын толгой гэж ямар юм байсан юм.Тэгээд л тэр чиньв амнаасаа гараад л ингэж дугураад л нөгөө дэх дөө долгоход яг таараад л.Эргэн тойрон тийм гинж зуусан, ухаан нь хамгаалалтын хэлбэрүүд байж л дээ.

Гантулга: Аан тийм байж ?

Дамиран: Гинж зуусан бадын толгой гэж.

Гантулга: Бадын толгой?

Дамиран: Бадын толгой.

Гантулга: Бад гэдэг нь?

Дамиран: Аа нэг амьтан л юм шиг байгаа юм. Арслангийн ам шиг.Тэрийг чинь одоо бүтэн тойроод үзвэл их сонин л доо.Тэгээд дээд талд нь тийм зууван, нэлээн зузаан тэгээд тэрүүгээрээ дээр нь гарник маягтай

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

өргөдөг.Тийм барилга байсан юм болов уу гэж.Тийм хэлбэр ч бас энд тэнд харагддаг. Одоо тэр нарийн үзээд байхад Эрдэнэдалайн, за миний мэдэх л тэр Сангийн далайн, Эрдэнэдалайн дуган л одоо голыг нь барьж өгнө дөө.

Гантулга: Одоо байгаа дуган нь уу?

Дамиран: Одоо байгаа дуган.

Гантулга: Ер нь одоо энийг нүдээр үзсэн хүн байгаа.Эндхийн бүр уугуул энд төрөөд тэгээд одоо бас нэлээн ахмад одоо амьд сэрүүн байгаа гээд түрүүн нэг хоёр хүний нэр хэлж байсан.Тэр үлсүүд одоо аль аймгийн аль сумын...?

Дамиран: Бямба гэж хүн үү. Бямба энэ сумын хүн. Одоо энэ Булганы нутагт яваа.Булган дээр очиход хэлж өгнө. Тэр мэдэж болно.Энэ Цэвэгмид энэ орчмын хүн байсан байх.Базарын Цэвэгмид.Ийм хоёр хүн л байна.

Гантулга: Хурлын одоо дотор өдөр тутмын хурал нь тийм чиглэлийн хурал хурж байсан, одоо шинийн найман, арван таван гээд дүйчэн өдрөө ийм хурал хурдаг байсан, сүсэгтнүүд ийм юм айлтгадаг байсан, одоо ингээд цам гардаг, сор залдаг байсан, тэрийг нь бол мэдэх юм, оролцож байсан энэ тэр?

Дамиран: Тийм юм байхгүй.

Гантулга: Энэ цогчин дуган дээрээ хэий тооны лам нар байсан бол, энэний талаар, хичнээн шавьтай байсан бол, энэ Шар Хулсны хийд?

Дамиран: Тэр талаар мэдэхгүй ээ.

Гантулга: Дотор нь одоо ямар сургалт, сургууль, одоо чиглэл чиглэлээрээ гүн ухаан зурхай, эм гээд одоо том зурхайч нар ч байдаг юм уу? Одоо ингээд л хүний янз бүрийн өвчин, эмгэгийг дардаг ч байдаг юм уу, том маарамба эд нар тийм үлсүүдын талаар их тарни, нууц тарни мэддэг одоо энэ уул усны лус савдагийг дардаг, дошгирсон тийм юуг яадаг, нэртэй үлсүүд байсан уу, тийм дуулсан юм байна уу?

Дамиран: Тийм үлсүүд байсан юм гэнэ лээ.

Гантулга: Аан дуулснаасаа яривал?

Дамиран:Тэр Азар лам гэдэг бол ерөөсөө гайхалтай лам байсан гэж байгаа ш дээ. Хаана одоо ямар аюул болох гэж байна тэрийг одоо шууд мэдэж байдаг.Тэгээд л нэг айлд одоо аюул сүйрэл болох гэж байна гэхлээр л урьчилаад очиж байдаг тийм хүн байсан гэж байгаа ш дээ.Тийм айхтар хүн байсан гэж байгаа.Тэгээд тэр Төвд хүн байсан юм шиг байгаа юм. Энийг ээж минь бол , хоёр ээж минь их Ярьдаг байлаа л даа. Ээ дээ одоо тэрнийг мэддэг хүн даанч байхгүй болж. Бид нар бол одоо тэр шашин сүм устаж сүйтгэсэн тэр үед төрчихсөн. За тэгээд ганц нэг хүнээ ярьж, сонин содон юм нь ингээд сэтгэл санаанд хоногшоод үлдчихсэн, тиймэрхүү юм байгаа юм.Тийм бүдэг, бадаг юм л ярих юм даа.

Гантулга: Одоо мэддэгээ л ...?

Дамиран: Ээ одоо тэр нь тийм байсан, тэр нь тийм лам байсан, тийм зурхай ч байсан, тэр тийм мундаг оточ маарамба байсан гэдэг тийм юм бол одоо мэдэх юм байхгүй юм.Аа тэр болвол ер нь бүгд л байсан юм гэнэ лээ.

Наян тохой Майдар гээд л тэр Хошуу хийдийн урд тэрнийг бол би үзэж байсан юм.Хүн бастэрэнд намайг бас

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

авч очиж байсан юм.Бас ч гайгүй зургаа, долоо настай болчихсон байсан юм .Тэгэхэд тэр наян тохой майдрыг буулгаад хаячихаагүй л байсан юм даа.

Гантулга: Тэр Майдар ер нь Хулсны хурлаас харагддаг байсан уу?

Дамиран: Ер нь үгүй байх.

Гантулга:Тэрийг бол мэдэхгүй юу?

Дамиран: Үгүй мэдэхгүй.

Гантулга: Холоос харагддаг байсан гэж бас хүн ярьж байсан?

Дамиран: Өө тэр холоос харагдалгүй яхав.Энэ Онгийн талаас ер нь харагдах байсан байлгүй.Газар нь уруу л даа.Сандал нь гээд энэ олон тэмээ шиг чинь байдаг байсан ш дээ.

Гантулга: Сандал нь гээд?

Дамиран:Тийм.

Гантулга: Суугаа Майдар бурхан байсан мю уу, тийм ээ?

Дамиран: Тийм.Тэндээ нэг эмжээртэй юм байсан юм.

Гантулга: Та түрүүн хэлж байсан ш дээ, хүүхэд байхад нь хөлийн хуруунд нь орж тоглож байсан гээд?

Дамиран: Тийм, тэгээд тэр чинь юу яаж байсан юм. Үгүй ээ би чинь тэгэхэд томроод зургаа долоотой байсан болов уу.Өнөө наян тохой майдрыг чинь буулгаад, бутлаад...Тэгээд хойд голд нутаглаж байсан даа, миний муу ээж чинь.Отор нүүдэл их хийдэг хүн байлаа.Тэгээд л энэ тэр Халзан Цэнгэл гэдэг хүн урлаж байж билээ , тэр наян тохой майдрыг хадаж байсан гээд ярьж билээ. Тэгээд энэ хөлийн эрхий хуруу, тэрүүнд нь бол би дүүтэйгээ ороод л тоглоно, энэ чинь.Үгүй тэрүүнд багтдаг л байсан юм/ инээв/. Хөлийн эрхий хуруу ш дээ.Үгүй тэр чинь тэгэхээр мөн том бурхан байж тарна аа даа/инээв/

Гантулга: Энэ Шар хулсныхаа хийдээ тойроод энэ хуваргууд нь ойрхон лам нарын хороолол гэж байсан юм болов уу, тэрийг бол мэдэх юм байна уу?

Дамиран: Ер мэдэхгүй юм, ёстой мэдэхгүй юм.

Гантулга: Бодвол хүрээн дээрээ л байсан байх даа, тийм ээ?

Дамиран: Тэгнэ биз. Тэр ламын байшин, энэ ламын байшин гэж ярьдаг л байсан.

Гантулга: Аа тэгэхээр энэ дээрээ л байх нь тийм ээ?

Дамиран: Аа нэг хагас хугас нь гэртэй, хагас хугас нь байшинтай ч байсан юм уу, үгүй юм уу.

Гантулга: Жас мастай байсан уу, ер нь?

Дамиран: Аан?

Гантулга: Тийм цогчин жас энэ тэр гэж байсан уу, цогчинүүдэд?

Дамиран: Ер мэдэхгүй юм.Үгүй тэгээд байсан байлгүй яхав, байсан юм гэнэ лээ хөөе.Тэр өнөө манж, цанлаваа хийдэг тэр л боов чанадаг нэг л их том онгоц байсан гэж ярьдаг байсан юм, манай муу эх.Тэрнийг л гурилаар дүүргэчихээд л,арваад банди хөлөөрөө, нүцгэн зүүрдаг байсан юм гэнэ лээ л гэж ярьдагсан./инээв/

Гантулга: Тэгэхээр л овоо боов хийдэг байж?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамиран: Тэгээд л онгоцонд гурил дүүргэхээд л , тэгээд өнөө шар тос асгаад хаячихна.Тэгээд л хөл нүцгэн арван бандиар тэрийг нухуулдаг байсан гээд...

Гантулга: Сүсэгтэн олон одоо таны ээж их сүсэгтэй хүн байсан юм ш дээ, тэгээд л энэ сүсэгтнүүд эргэл мөргөл их хийдэг байсан байна?

Дамиран: Тийм.

Гантулга: Өөрөөр одоо ямар зан үйл хийдэг байсан бэ, шүашан ызан үйл одоо таны мэдэхээр болвол? Янз бүрийн сахил махил авах ч байдаг юм уу, ламаас ном аваад нэг өдрийн сахил авах ч байдаг юм уу, эсвэл янз бүрийн одоо сүм хийд болж байсан том том одоо сор залах, бурхан аравнайлах ч байдаг юмуу сүм хийд аравнайлах ч гэдэг юм уу том үшйл ажиллагаанд хүмүүс ирвэл сүсэгтнүүд яаж ханддаг байсан, одоо ингээд шар тос мос өргөдөг ч гэдэг юм уу, хадаг өргөдөг ч гэдэг юм уу, тийм нэг зан үйлүүд байна ш дээ? Буян хйих маягийн, одоо?

Дамиран: Аа хадаг нь , тэр самбай хадаг гээд одоо зулын шар тостой барьдаг л байсан л даа.Самбай хадаг гээд нэг ямар ч юм байсан билээ дээ, нэг самбай хадаг л гэж ярьдаг л байсан юм.Тэгээд нэг зулын шар тостой тэгээд тэрнийг л өргөнө.Тийм л юм санаанд байгаа юм даа.Тэгээд эндээс чинь тэр болгон ирж очдоггүй байсан болохоор бас сайн мэдэхгүй юм аа.Тэгээд л жинхэнэ нэг ухаан ороод л овоо болчихсон байхад чинь энэ чинь хэдийний байхгүй болчихсон байгаа юм чинь.Лам нар чинь, намайг мэдээ орох үед...Зайдан тэмээн дээр нэг хоёр гурван хүн зайдан унуулчихсан, шар тэрэгтэй, тэгээд нэг хоёр тэмээтэй. Одоо тэр цагдаа л байж дээ. Туугаад л явж байсан, тэрийг санаад салдаггүй юм.Тэр чинь одоо ямар ямар улсууд гэж байлаа даа, тэрийг одоо ярьдаг л юм.Тэгээд мартчих юм чинь.Тэгээд тэр хамгийн сүүлийн баривчилга байсан байх гэж би боддог юм.Нэг хоёр гурван хүн л байсан юм даа, зайдан тэмээ унуулчихсан.Хоёр хүн туугаад явж байсан.Тэгээд миний мүү эмэг эх л , хөөш энэ чинь сүүлчийнх л юм байх даа, энэ барагддаггүй л юм байх даа гээд л ярьж билээ дээ. Тэр Баянхошууны амаар оруулаад тэгээд л туугаад л алга болсон доо.Тэд нар тэгээд хөөрхий минь байхгүй болсон л юм байгаа юм.

Гантулга: Энэ одоо сүм хийдийн хутагт хувилгаан, лам хуваргын талаар одоо тийм ид шидтэй лам байсан, тэр азар лам нь ингэдэг байсан гээд нэг түүх домгууд байдаг ш дээ.Тэгж бороо орулж гэнэ, ийм одоо дошгин сахусыг аргадаж дарж номхруулж гэнэ ч гэдэг юмуу, тэр талаар?

Дамиран: Үгүй ээ тэр овоо тахина , бороош оруулна гэдэг чинь үнэхээр тэр үедээ бол хүчтэй байсан юм шиг санагддаг юм.Овоо дошгин байхад ер нь заавал бороо ордог.Тэгэхээр тэр овоо тахьсан ламын ид шид бол мундаг л байсан байх гээд байхгүй юу даа.

Гантулга: Тийм тэгэлгүй яахав.

Дамиран: Тийм, ид шид бол мундаг л байх гэсэн байж байгаа юм.Энэ чинь одоо пионерийн овоо гэдэг нэртэй л болчихсон байгаа юм.Намайг багад...

Гантулга: Өминө нь ямар?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамиран: Өмнө нь тахилгат.Тахлгат овоо гэж энэ чинь том овоо байлаа.Тэрэн дээр чинь одоо тэгээд, одооны үед блол мах захаар л тахиж байх юм даа, тэгээд дээр үед бол цагаан идээгээр л тахидаг байсан гэж ярьдаг юм, чухам.Аль нь үнэн худлыг мэдэхгүй юм даа.За ямар ч байсан энэ овоо тахиад бороо орно гэдэг бол үнэн л байсан юм.Яриагүй л үнэн байсан юм, бөх барилддаг, морь уралддаг.Тиймл байсан одоо, за тэгээд тэр томоохон овоон дээр чинь эрт ирчихээд л хуц ухна гаргадаг, за эмэгтэйчүүд нь бараг оччдоггүй байсан юм шиг байгаа юм.

Гантулга: Одоо бүр нэг бадарчны тухай үлгэрүүд байдаг ш дээ.Тэрэнтэй адилхан одоо нэг тийм айхтар бадарчин байжээ гэдэг ч юмуу, тийм тухайн нэг хүн дээр чиглэсэн бодитой домог сонссон юм байвал?

Дамиран: Тийм юм байлгүй дээ. Лут лут бадарчин байсан юм гэсэн.Бадарчин хүн гэдэг чинь заавал өндөр номтой, тарнтай, жаягтай, жудагтай, хаа ч явсан биеэ аваад явах чадвартай, хаа ч явсан хурал дуганд ном хурчихаж чаддаг тийм чадалтай хүн л бадарчин хийж байсан гэж байгаа ш дээ. Зүгээр энэ мань мэтийн юу ч мэдэхгүй юм нэг хоёр мод чирээд явна гэж байхгүй.

Гантулга: Одоо энэ Шар хулсны хийд маань эргэн тойрон тахидаг овоо тахилга байна гэж байгаа ш дээ.Тэрийг нь одоо нэрлэвэл, одоо Баруун талд Тахилгат овоо, ингээд баруун хойшо, урагшаа, зүүн хойшоо гээд зүг чигээр нь нэрлэвэл?

Дамиран: Өө энэ баруун тийш Голын мандал гэж нэг том овоо бий.

Гантулга: Аа мөн.

Дамиран: Голын мандал гэж. Тэгээд энэ хойшоо ч байдаг юм гэнэ лээ, энэ зүүнтээ Ишхонгорт бас одоо ч байж байдаг, тахидаг овоо байсан л гэж байгаа юм.Одоо тэр овоо бол байж л байдаг юм.За энэ үрд талыг бол сайн мэдэхгүй байгаа юм аа.Батхүү дуулсан юм байдаг л байлгүй.Хойд чигт бол наана нь мэдэх гурван тахидаг овоо л байсан шиг болоод байгаа юм.Хонгор, тэгээд Хөтөгийн нэг овоо л байсан юм шиг байгаа юм. Баруун мандал гэж нэг том овоо бий дээ ,бас.

Гантулга: Тэр Хөтөгний гэсэн үү, хойшоохыг?

Дамиран: Тийм.

Гантулга: Хөтөгний гол гэсэн үү?

Дамиран:Тийм тийм .

Гантулга: Түрны голыг хэлж байна үү?

Дамиран: Аа мөн мөн. Тэр хавьд чинь нэг гурван тахидаг овоо байдаг юм байна лээ.Би үзээгүй. Тийшээ бол бас тахидаг л байсан байгаа юм.

Гантулга:Яаж тахидаг энэ тэр талаар нь бол дуулсан юм байхгүй?

Дамиран: Дуулсан юм байхгүй.

Гантулга: Сүм хийд ингээд хаагдаж нурсан ш дээ, тэгэхэд та яг хэдтэй байсан, тэр үед яг харж, дуулсан барьсан юм, лам нарыг яаж хэлмэгдүүлж байсан? Одоо ингээд тухайн орон нутагт чинь засаг захирганы хариуцлагатай ажилтан нь ямар улсууд байсан , тэд нар нь яаж оролцож байсан тэр талаар мэдэх юм байна үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамиран: Мэдэх юм байхгүй.

Гантулга: Аа мөн.

Дамиран: Тэр талаар бол ерөөсөө мэдэх юм байхгүй.

Гантулга: Зүгээр яахав тэр...?

Дамиран: Тэр лам нар ч чинь хэдэн онд ч татагдсан юм, мэдэхгүй.

Гантулга: Тэр зүгээр бурхан тахил шүтээнүүдийг нь тэр юуны агуд нуусан энэ тэр гээд түрүүн нэг дурсаж байсан.Тэр талаараа дэлгэрүүлээд лам нар нь өөрсдөө хэлмэгдүүлэлтээс зугтаагаад ч гээдэг юм уу, гамингуудаас зугтаагаад ч гэдэг юм уу, тэр нуугдаж хоргодож байсан газар, ном судраа нууж байсан талаар?

Дамиран: За энэ ийм юм байгаа юм.Тавин гурван оноос эхэлж төв газар луу, тавин гурван оноос анхны шороо эхэлж байсан гэдэг тэр бол үнэн.Тавин гурван онд чинь анхны шороо эхэлж байсан гэж байгаа юм.Тэрнээс өмнө бол шороо тавьж байгаагүй, зүгээр нэг хааяа угалз тавьчихаад л больчихдог, тэгээд л бороо орж л байдаг. Тийм л байсан.Энчээ чинь одоо заг гэдэг ургамал ч байхгүй болсон л үе. За тэр үед л тэнгэр хангай хилэгнэж байсан юм байлгүй дээ.Энэ шороо гэдэг чинь тавин гурван онд эхэлж байлаа.

Гантулга: Ер нь тэр заг нь багасахаар шороо эхэлж байсан байх нь ээ?

Дамиран: За би тэгж л боддог юм. За тэгээд тэр янз бүрийн шороо тавьдаггүй байхад чинь энэ улаан цавын зүүн үзүүрт чинь том агуй байлаа.Наст гэдэг хүн хавхтай үнэг алдчихаад...

Гантулга: Юу алдчихаад аа?

Дамиран: Хавхтай үнэг.Би чинь одоо том оо болчихсон, долоо наймтай болчихсон. Уран Жамъян гэж нэг өвгөн байлаа. Тэр манайтай айл.Наст гэдэг хүн одоо тэгэхэд залуухан байж.Нэг цахиур буутай л , нэг үнэг агуйд орчихсон юм шиг байх юм. Би ганцаараа орох гэсэн чинь айгаад гээд хүрч ирж, би ч тэгээд зүггүйтэж, хүүхдийн юугаар...Жамъян өвгөнийг дагаад шаачихсан.Тэгэхэд чинь тэр нэг нэг их өндөр хошууны ёроолд яг зүүн урагшаа харчихсан хүн нэлээн сайн тонгойж орохоор тийм улаан нүх байна.Тэгээд өнөө чинь тэрүү лүү орлоо шүү.Өнөө Наст л нэг муу цахиур буутай /инээв/ Цахиур буу барьчихсан, ингээд нөгөө нэг хөх модон шаадамтай, нөгөө шаагилаа би ч айж сүйд боллоо доо. Ингээд л нэг түнэр шиг юм байна.Эргэлдсэн улаан юм болдог өнөө чинь.

Гантулга: Юу болов, энэ чинь юу байна гээд л ?

Дамиран: Тэгээд л өнөө чинь агуй юм даа.Тэгээд л нэг муу лаа шатаачихсан.Лаа дальдрана барина ч гэж байхгүй дээ, ингээд ганц лаа шатаачихсан.Тэгсэн чинь этр, том агуй байсан шиг санагдаад байгаа юм.Тэгээд явж байсан чинь тэгсэн чинь нэг шовгор юу юм бэ дээ, дээр нь нэг бага малын шатчихсан чөмөг нэг тийм юм байдаг юм байна, өнөө чинь.Тэрэн дотор хоол үнд хийж байдаг байж л дээ.

Гантулга: Лам нар хоол хийж байсан байх нь ?

Дамиран: Тийм, тэгээд тэр хойно нь одоо тэр яг санаанд байдаг юм.Нэг их бар арслангийн зураг шиг, нэг их эрээн юм.Үгүй ээ тэр юу вэ, тэр юу вэ гээд л өнөөхийг чинь.Тэгээд л тэр Жамъян гуай чинь ямар зүг байхав дээ, мундаг эрдэмтэй хүн байсан юм.Аа энэ бурхан тахилын л юм байгаа бахй. Нэд даяан хийж байсан юм гэнэ лээ

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гээд л өнөөхийг чинь тэгж байсан.Тэр Жамъян гуай, Наст хоёр л санаанд байдаг юм.Би тэгээд л тэр Жамъян гуайн хормойноос зүүгдчихнэ.Ингээд л явж байсан чинь аа бурхан шүтээн байна, бурхан шүтээн байна гээд л очлоо доо. Тэгсэн чинь ингээд нэг их зүмбэртэй тийм ширээ.Тэрэн дээр өнөө бурхан тахил номыг чинь ингээд л хураачихсан, учир байхгүй. Тэгээд л нөгөө янз бүрийн бойпор, цөгц үгүй ерөөсөө жигтэйхэн.Хонх дамар тийм юм байсан юм.Тэгээд тэгчихээд тэр үнэгээ олоогүй.Ер нь сүүлд нь ч айсан байх.Тэгээд л энэ би их ухаан алдаж байгаа юм , ерөөсөө/инээв/

Гантулга: Тийм аймар бурхан тахил олон юм үзээгүй байсан?

Дамиран: Тийм.Үгүй ер нь тэгээд л энд л орсон мөр байх шиг байсан юм.Яах аргагүй л энэ лүү орсон байсан юм даа.Газар нь хатуу байсан юм чинь.Энэ рүү л яах аргагүй орсон байсан юм даа.Тэгээд л алга байна даа гээд л , тэгээд сайн ч тойр чадаагүй.Тэр бол том агуй. Тэгээд тэрний чинь тэр Уран Жамъян шинжлэх ухааны хүрээлэн гэж байсан юм уу даа. Тэнгд энд нэг ийм юм байна гээд бичиг явуулсан гэж байгаа ш дээ.Тэгсэн тэр хүн нь ирээгүй гэж байгаа юм.Ерөөсөө ирээгүй.Ийм сонин юм байна, энийг үзэж хараач гээд ерөөсөө ирээгүй.Тэгээд тэрүүнд бол, одоо тэр жаран хээдн оны үед болж байна даа.Тэрүүнд чинь тэгээд үзэж ойртдоггүй ч байсан байх, их бурхан шүтээнтэй ууланд: Их дошгин газар байсан юм шиг байгаа юм. Ойртож болдоггүй газар, дүүрэн бурхан сахиус лут ,бусын юм байгаа гээд л .Надад ч л гэсэн захиж л байсан, ойртож болохгүй шүү гэж, тэр Жамъян.Чи явбал чамайг чинь дор нь бариад идчихнэ шүү гээд л/ инээв/ Тэгээд далан хэдэн онд энэ нутагтаа нэг амралтаар ирээд өнөө газраадаа очих ч юм байхгүй.Ерөнхий нэг төс энэ л багцаанд байсан байгаа даа гэж л бодож байгаа юм.Дөч, тавиад метр бараг бий байх аа.Шороо ингээд шуураад хонхорлоод...

Гантулга: Юу ч үгүй дараад хаячихаж?

Дамиран: Дараад хаячихсан.Тэгэхээр энэ тавин гурван оноос өмнө шороо тавьдаггүй байсан гээдг чинь үнэн байгаа биз.

Гантулга: Тийм байна.

Дамиран: Дээр үед чинь ерөөсөө бүх юм, энэ амнууд чинь шороо элс юм байхгүй. Нэг жаахан тийм хөх хайрга нурангитай тийм газар л , жаахан өвс ургаад л , амьтан шуугиад л тэгдэг байсан.За энэ Ханын хурлын Дөрвөн хананых гэж бас нэг газар бий.Тэрний энүүхэн доор баруун урагшаагаа бас нэг ам бий дээ, Батхүү ч одоо үзсэн ч байж магадгүй.Том ам аа, тэгээд урд талдаа өндөр хадан хясаатай, хойд тал нь нэлээн налууухан.Ингээд налаад ирсэн, тэгээд ёроолдоо задгай устай.Энэ тал нь их сайхан хадан хясаатай.Тэрэн дээр одоо нэг гоё угалз, цагаан.Чулуун угалз, том угалз аа.

Гантулга: Чулуугаар хийчихсэн угалз?

Дамиран: Тэгээд тэрнийг би хадаасаао ухаад нөгөө хүүхэд байхад хурга хариулж байгаад.Тэр задгайд хурга усалж, тэр хадаасаар ухаад.Тэгсэн чинь хачин гүнзгий юм байдаг юм байна лээ ш дээ.Нимгэхэн угалз байгаа юм, тэгээд шохой биш.Ерөөсөө тэр хаашаа юм, тэр байгалиас тэгдэг байгаа юм.Үгүй тэгээд тэр сийлээд чулуу шигтгэсэн байдаг юм.Тэр чулуу бол ерөөсөө үргэлжээд, зүгээр л цагаан чулуу ш дээ.Одоо тэр их гоё байгаа юм.Янз бүрийн угалзтай их том дөрвөлжин хүрээтэй.Тэгээд одоо миний нүдэнд бичээтэй л байж байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр бол одоо тийм байгалийн...?

Дамиран: Тэр бурханд нь байсан юм л даа, хуу хураадаг.Тэгээд л бурхан ном их байна.Тэгээд л би чинь , тэрнийг чинь хүүхэд байхад чинь аваад л үзнэ, тэр хонио хормойд тогтоочихоод л ...Тэгээд л тийм бурхан байна, ийм бурхан байна , ном судар байна, тийм том бурхан байна гээд л эхдээ хэлээд очно.Ээ базарваани , миний хүү дахиж битгий тийшээ очоорой.Аман дээр чинь бөөн яр гарна шүү гээд л сүйд болно.Лусын хорлол болно дахиж битгий очоорой ингээд л тэгнэ.Тэгээд л би ч одоо, миний сонирхол л байдаг байх даа, бас үгэнд ордоггүй л хүүхэд байсан. Байж байгаад л хааяа очиж үзнэ.За тэр Баянхошууны чинь энэ талд нэг хэдэн агуй бий.Тэр чинь бас нэг хэсэг мундаг...

Гантулга: Баянхошуунаасаа зүүн урагшаа юу?

Дамиран: Тийм, за тэгээд түүнээс хойш чинь би нэг арвад настай байсан юм уу, араь ч хүрээгүй байсан юм уу.Энэ тоочгийн мал босгоно гээд л оросууд их явдаг байлаа.Тэгээд л энэ тэнд нэг гурван хөлтэй, шовойсон юм...Үгүй тэр үеэр эхэлж л тэр бурхан ном алга болсон болов уу гэж боддог юм.

Гантулга: Оросууд түүчихсэн гэсэн үг үү?

Дамиран: За тэгсэн л болов уу, бас мэдэхгүй ээ.Энэ Батхүү мэдэх юм уу.Үгүй тэр сүүлийн үед л тэгээд тэр бурхан ном алга болчихсон юм байгаа юм. Аа зүгээр амьтан аваад далд дам хийгээд хадгалсан ч байхыг хэн мэдэхэв.Сайхан сайхан бурхан ном одоо тэгээд л тэр хаданд л хийнэ дээ.Одоо тэр хөдөөний айлууд чинь тэр бурхан тахил шүтээд байж байх эрх байхгүй.Тэр ч байтугай миний муу эмэг эх авдран дотор, хоосон авдран дотор зулаа өргөдг байлаа шүү дээ.

Гантулга: Нууцаар?

Дамиран: Тийм, нууцаар зулаа өргөдөг байлаа шүү дээ.Тэгээд сүүлд нь өнөөхийг нь баригдаад жаал зулынхаа тосыг хураалгаж байсан юм шуу даа./инээв/

Гантулга:Ерээд оноос хойш бурхан шашин шүтэх бишрэх чөлөөтэй болох үед бол энэ сүм хийд сэргэж барьсан юм бол байхгүй юм байна ш дэ, тийм ээ?

Дамиран: Байхгүй байхгүй.Сэргэх ч үндэс байхгүй.

Гантулга: Юу ч үгүй ингээд талхлаад?

Дамиран: Юу ч үгүй сүйдсэн юм чинь ямар юмаа сэргэх вэ.

Гантулга: Сумын төв дээрээ бол дуган, муган ерөөсөө юм байхгүй юм байна ш дээ, ойр хавьдаа бол?

Дамиран: Байхгүй.

Гантулга: Лам хуварга ч, хурал номын газар тийм юутай юм байна?

Дамиран:Тийм.Энэ сумын нэг үгүй нэг ламтай болох юмсан гэж ярьдаг юм ш дээ, олон түмэн. Одоо нэг суварга барих юм гэнэ лээ.Сураг дуулдсан. Та нар үзсэн үү?

Гантулга: Үзсэн, танай засаг дарга ярьж байна лээ.Нэг дуганы төсөл гаргачихсан байна лээ.Тэгээд санал хүсэлтээ уламжлаарай.

Дамиран: Тийм.Тэгээд нэг ламтай болох юмсан л гэж...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ Хулсны хурлын хүрээий, хийдийн нэг гар зураг байдаг ш дээ. Хуучны бурханч лам нар зурсан юм уу, уран улсууд?

Дамиран: Тийм.

Гантулга: Тийм зураг та үзэж байсан юм байна уу? Ер нь айлд ч юмуу тийм үзэж харж байсан удаа байна уу?Энэ Шар Хулсныхаа хүрээ хийдийн зургийг?

Дамиран: Өө үгүй үгүй.

Гантулга: Үзээгүй юу?

Дамиран: Үзээгүй.

Гантулга: Тэр талаар бичсэн барьсан юм бол мэдэхгүй юу?

Дамиран: Мэдэхгүй.

Гантулга: За мэдээлэл өгсөн , сайхан ярилцлага өгсөн таньд баярлалаа.

Дамиран: За зүгээр ээ.

Гантулга: За та тэр Тожгон тооны бүгийн тухай нэг ярина уу?

Дамиран: Тэр Тожгон тооны буг гэдэг чинь жинхэнэ л бодит домог юм даа. Зүгээр нэг тийм хийсвэр, уламжлагдсан олонд мэдэхгүй яриа биш юм.Энэ болвол одоо тэр 1907, 1908 онд болж байсан юм шиг байгаа юм.Одоо тэр Дашдавааг л хүүхэд байсан гэхэд.Тэгэхэд бол тэр нэг Галдан тэнэмэл гэж нэг айл байж дээ , одоо.Тэр хавиар л тэр Дашдаваагийн л хамаатан байсан гэж байгаа.Миний мүү ээж минь жаахан охин , тэгээд тэр айлд зарагдаад бас байж байсан юм шиг байгаа юм.Тэгтэл гэнэтхэн ингээд л үдийн цай чанаж байхад гэнэтхэн тогоотой цай руу нь тог гээд л нэг юм оочдог.Энэ чинь одоо нөгөө цай май цалгиад л ...

Гантулга: Цалгиад л , халуун тогоотой?

Дамиран: Тэгээд юу байж байсан, хавтгай чулуу байж байсан байгаа юм. Тэр чулуу нь хаанахын чулуу байсан бэ гэхлээр Мөрөвчийн хярын чулуу байсан байгаа юм.Мөрөгчийн хярын...

Гантулга: Тэр нь эндээс хэр хол байх уу?

Дамиран: Бүр хярдаа. Энэ хавтгай артай хөх чулуу байдаг юм.Тэгээд Мөрөвчийн хярын чулуу байна, энэнээс өөр ийм чулуу байдаггүй гэж тэгж байсан гэж байгаа юм.Тэгээд тэр Дашдаваа гэж , одоо ер гарчихсан, ерэн хэд хүрчихсэн хөгшин байгаа, тэр тэмээнд явдаг байсан байгаа юм.Тэгэхэд тэр нэг дах нөмөрсөн хүн орой уулздаг байсан байгаа гэж.Одоо манай ээжид л ярьдаг байж.Тэгээд одоо тийм хүнтэй уулзлаа. Тийм, янзтай, нэг дах нөмөрсөн хүн зуун тэмээ ороолгоод явж байхад өвөл зунгүй уулзсаар явчихдаг.Тэгээд л тэр тэмээ нь ямар янзын тэмээ байсан юм, нэг сахалтай хүн л байсан гэж байгаа юм.

Гантулга: Яг байр байдал нь: